



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**БҮРТГЭЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ПРОГРАММД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХОЁР
ПРОГРАММЫИН УЯЛДАА ХОЛБОOG САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД САНХҮҮ
ТАТВАРЫН ТАЙЛАНГ ТУ БОЛОН САЛБАРЫН ДҮНГЭЭР БАЛАНСЫН ХЭМЖЭЭНД
НЭГТГЭЛ ПРОГРАММ НЭВТРҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: Бүртгэл төлөвлөлтийн программд нэмэлт өөрчлөлт оруулах, хоёр программын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд санхүү татварын тайланг ТУ болон салбарын дүнгээр балансын хэмжээнд нэгтгэл программ нэвтрүүлэх

Тендерийн дугаар: ЦДҮС-2019/ХА30

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ҮННИЙ САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “Бүртгэл төлөвлөлтийн программд нэмэлт өөрчлөлт оруулах, хоёр программын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд санхүү татварын тайланг ТУ болон салбарын дүнгээр балансын хэмжээнд нэгтгэл программ нэвтрүүлэх” гүйцэтгэгчийн тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 09:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДУС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 09:10 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн
өргөн чөлөө-45,**

**“ЦДУС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар, 309 тоот
Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс
Утас: 99039494 Факс: 976-70043287**

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Унийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫ ХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн нэг жил буюу 2018 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн хоёр жилийн ижил төстэй ажил хийсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/ - Шүүхийн тодорхойлолт, мэргэжлийн үйл ажиллагаандaa алдаа гаргаж байсан эсэх (харьяалах шүүхийн тодорхойлолт), - Татварын цахим тодорхойлолт. - Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт. (Улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээр) - Нийлүүлэх програмын дэлгэрэнгүй танилцуулга, үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлэх. - Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл. (диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна.) - Төв компани болон 5 салбарт нэвтрүүлэлт хийж, сургалт зохион байгуулах - Програм хүлээлгэн өгч гэрээ дүгнэсэн хугацаанаас хойш 1 жилийн хугацаанд үнэ төлбөргүй засвар үйлчилгээ үзүүлэх - Компанийн дэлгэрэнгүй танилцуулга. - Тендерийн хэл Монгол хэл дээр байна. <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр цахим системээр илгээх.</p> <p>Цаг: 09 цаг 00 минут.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот-21013, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДУС” ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-н дахар, 314 тоот Огноо: 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр Цаг: 09 цаг 10 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>“Бүртгэл төлөвлөлтийн программд нэмэлт өөрчлөлт оруулах, хоёр программын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд санхүү татварын тайланг ТУ болон салбарын дүнгээр балансын хэмжээнд нэгтгэл программ нэвтрүүлэх” ЦДУС-2019/ХА30</p>
Бусад:	Хөнгөлөлт урамшуулалт үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.

Гурав.БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бүртгэл төлөвлөлтийн программд нэмэлт өөрчлөлт оруулах, хоёр программын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд санхүү татварын тайланг ТҮ болон салбарын дүнгээр балансын хэмжээнд нэгтгэл программ нэвтрүүлэх	Техникийн тодорхойлолт	1	Иж бүрдэл	“ЦДУС” ТӨХК	30 хоног	60 хоног	

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бүртгэл төлөвлөлтийн программын ажлын даалгавар

1. Програм хангамжийн шаардлага

1.1 Системийн зорилго

Дамжуулах сүлжээний санхүүгийн их хэмжээний бүртгэл, өгөгдлийн зохион байгуулалт болон үйл ажиллагааг сайжруулах зорилгоор эдийн засгийн төлөвлөлтийн программын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт болон нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэх шаардлагатай байгаа болно.

Эдийн засгийн төлөвлөлтийн программын гол зорилго нь цахилгаан дамжуулах үйл ажиллагаанд хамаарах бүх санхүүгийн тооцоо, бүх зардал, ТЗБАХ, ИЗ, УЗ болон бусад мэдээллийг нэгдсэн санд бүртгэн оруулах, шуурхай дүн шинжилгээ, тайлан бүртгэл хийх үйл ажиллагааг сайжруулах, төлөвлөх болон шийдвэр гаргах явцад санхүүгийн ажилтан нарыг мэдээллээр хангахад оршино.

1.2 Ерөнхий шаардлага

Системийн ерөнхий шаардлага:

Тус систем нь веб програмчлалын хэл дээр сууринсан цахим бүртгэлийн систем байна. ЦДУС ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэнэ. Тус системийг цаашид ЦДУС ТӨХК –ийн бүх салбар үйл ажиллагаандаа ашиглаж, бусад мэдээллийн системтэй (Payroll, Diamond, ДСУМС, ТМНС) уялдаж ажиллах боломжтойгоор загварчилсан байна.

Хэрэглэгчийн шаардлага:

- Монгол хэл дээр, UNICODE ашиглана.
- Мэдээллийг нэг оруулж, олон дахин ашигладаг байх.
- Анхан шатны бүртгэлүүдийг баталсан маягтын дагуу бүртгэл хөтөлдөг байх.
- Бүх бүртгэлийн түүхчилсэн сан хөтөлдөг байх.
- Анхан шатны бүртгэлүүдийг компанийн бусад салбар дотроо мэдээллийн сантай холбож мэдээлэл солилцох боломжтой байхаар шийдсэн байх.
- Бүх бүртгэлээс бүх талбараар төрөл бүрийн хайлт хийж, үр дүнг гаргах хайлтын системтэй байх.
- Хэрэглэгчийн эрхийг цэс, үйлдэл бүрээр зохицуулдаг тусдаа дэд системтэй байх.
- Тайлангийн иж бүрэн дэд системтэй байх. (Батлагдсан маягтын дагуу)
- Гарын авлага Монгол хэлээр байх.

Техникийн шаардлага:

- Компанийн дотоод болон гадаад сүлжээнд ажилладаг байх;
- Хэрэглэгч ашиглахад ойлгомжтой хялбар байх;

1.3 Ажлын даалгавар

1.3.1 Гүйцэтгэгчийн ажлын даалгавар

Гүйцэтгэгч нь уг төслийн хурээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2019 оны А/98 тоот тушаалаар батлагдсан “Бизнес төлөвлөгөө боловсруулах нэгдсэн маягт”-ын дагуу тайланг програмаас нэгтгэн гаргадаг болгох
- ЭХЯ, ЭХЗХ болон Хан Уул дүүргийн статистикийн газарт гаргадаг мэдээ тайланг батлагдсан загварын дагуу нэгтгэн гаргах
- Санхүүгийн шинжилгээ хийх
- Хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчийн өмчийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ
- Төлбөрийн чадварын шинжилгээ
- Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ
- Эргэцийн шинжилгээ
- Бүтээмжийн шинжилгээ
- Үндсэн хөрөнгийн шинжилгээ
- Орлого, үр дүнгийн шинжилгээ
- Ашигт ажиллагааны шинжилгээ
- Зах зээлийн идэвхжлийн шинжилгээ
- Мөнгөн урсгалын шинжилгээ
- Даймонд болон эдийн засгийн төлөвлөлтийн програм хооронд үндсэн хөрөнгийн мэдээлэл солилцдог болгох
- Компанийн тайлант жилүүдийн Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг Эдийн засгийн програм болон ДСУМС програм хооронд мэдээлэл солилцдог болгох
- Интерактив компанийн Diamond болон Paytoll програмтай мэдээлэл солилцож, дээрх програмын мэдээллийн баазаас хүссэн загварын дагуу тайлан гаргадаг болгох
- Тайлангийн систем хийх

Системийн загварчлалаас гадна гүйцэтгэгч нь програм хангамж, техник хангамж болон одоо байгаа өгөгдөл цэгцлэлт хийхэд тохиromжтой аргачлалыг боловсруулна. Системийг ашиглах эцсийн хэрэглэгчдэд ойлгомжтой түүний хэвшиж дассан интерфейс бүхий хайлтын системтэй байна. Хайлтын зорилго нь тодорхой өгсөн шалгуураар санхүүгийн бүх мэдээллийг хялбар олох, тайлангаар харуулах боломжтой байна.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Нямсамбуу танаа**

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч шалган турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Баталгаат засварын хугацаа 12 сар байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гарган

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> | <p>1.1. Барааг хүлээн авахаас өмнө мэдээлэл технологийн хэлтсээр шалгуулж туршилт хийлгүүлнэ.</p> |
| <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| | <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p> | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Чанарын баталгаат хугацаа 12 сар байна.</p> |
| <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> | <p>7.1. Гэрээний өрөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний гүйцэтгэлийн хувиар санхүүжигдэнэ</p> |
| <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</p> | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн 0.05% байна.</p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 5%-иас хэтрэхгүй.</p> |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг

Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол ёгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]